



МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН
ҮНДЭСНИЙ ПАРКЫН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2015 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 030

Улаанбаатар хот

БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ
БАТЛАХ ТУХАЙ

Төрийн болон орон нутгын өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10дах заалт, Мэдээллийн технологийн үндэсний паркын Дурмийн 8 дугаар зүйлийн 8.5.8 дах заалтыг тус тус үндэслэн

ТУШААХ нь:

Нэг. “Мэдээллийн технологийн үндэсний паркын Аутсорсингийн бодлого”-ыг хавсралт ёсоор баталсугай.


Хоёр. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллах төлөвлөгөө гарган ажиллахыг Инкубатор, бизнес хөгжүүлэлтийн төв /П.Наранцэцэг/-д даалгасугай.

Хоёр. Энэхүү тушаал батлагдан гарсантай холбогдуулж байгууллагын нийт ажилтан, албан хаагчдад танилцуулж, хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн газар/Ц.Эрдэнэлхам/-т даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Б.МЯГМАРНАРАН



95
Мэдээллийн технологийн үндэсний паркын
эрөнхий захирлын 2015 оны 11 сарын 11. одрийн
10. тогт тушаалын хавсралт

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ПАРКЫН АУТСОРСИНГИЙН БОДЛОГО

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү бодлогын баримт бичгийн хүрээнд аутсорсинг гэдгийг ойлгоходо байгууллага их цаг, хөрөнгө, хүч шаардлаг ажлуудыг бага зардлаар түргэн хугацаанд чанартай хийж гүйцэтгэхийн тулд мэргэшсэн байгууллага, хувь хүнтэй харилцан тохиролцож хөлсөөр гэрээлэн ажиллуулах гэж ойлгогдоно.

1.2 Энэхүү бодлогын баримт бичгийн зорилго нь Паркын аутсорсингийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийн хүрээнд гадаад, дотоод аутсорсингийн үйл ажиллагааг хөгжүүлэх, инкубатор, технологийн компаниудын бизнесийн үйл ажиллагааг аутсорсингоор дэмжих, инкубатор, технологийн компаниудад аутсорсингийн үйлчилгээ үзүүлэх орчин нөхцлийг бий болгоход баримтлах бодлогыг тодорхойлоход оршино.

1.3 Аутсорсингийн үйл ажиллагаанд оролцогч талууд гэсэн ойлголт нь дараах утгаар тайлбарлагдана. Үүнд:

- 1.3.1 Парк цаашид Аутсорсингийн үйл ажиллагааг хэрэгжүүлэгч буюу зохион байгуулагч гэх;
- 1.3.2 Ажил захиалагч цаашид Аутсорсингоор ажил захиалагч гэх;
- 1.3.3 Технологийн болон Инкубаторын компани цаашид Аутсорсингоор ажил гүйцэтгэгч гэх;

Хоёр.Баримтлах зарчим

2.1 Инкубатор, технологийн компаниудыг аутсорсингоор ажил гүйцэтгэх, тэдэнд ижил тэгш өрсөлдөх бололцоо олгох;

2.2 Аутсорсингоор ажил захиалагч, Аутсорсингоор ажил гүйцэтгэгч, Аутсорсингийн үйл ажиллагааг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагааг дэмжих;

2.3 Аутсорсингийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн хамгаалах;

2.4 Аутсорсингийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ Мэдээллийн технологийн үндэсний паркаас батлан мөрдөж буй дүрэм журам, эрх зүйн үр дагавар бүхий баримт бичиг, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжыг баримтлан ажиллах;

Гурав. Бодлогын зорилго

3.1 Парк нь мэдээллийн технологийн аутсорсингийн хөгжилд түүчээ болон манлайлах, инкубаторын болон технологийн компаниудыг аутсорсингийн үйлчилгээг ашиглан үйл ажиллагаа болон санхүүгийн хувьд өндөр хэмжээнд төлөвшин тогтсон компани болгон олон улсын зах зээлд өрсөлдөх боломжыг нээж өгөхөд оршино.

Дөрөв. Аутсорсингийн үйл ажиллагааны чиглэл, хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1 Парк нь бодлогыг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ. Үүнд:

4.1.1 Аутсорсингийн үйл ажиллагаанд оролцогч талуудын хамтын ажиллагааг дэмжих, аутсорсингийн үйлчилгээг нэвтрүүлэх нөхцөл бололцоог нэмэгдүүлэх чиглэлээр;

4.1.2 Инкубаторын болон технологийн компаниудын аутсорсинг эрхлэх үйл ажиллагаа, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх;

4.1.3 Аутсорсингийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, мэдээ мэдээллээр инкубатор, технологийн компаниудыг ханган ажиллах;

4.2 Парк нь бодлогын чиглэлээ хэрэгжүүлэхдээ дараах арга хэмжээг авна. Үүнд:

4.2.1 Аутсорсингийн үйл ажиллагаанд оролцогч талуудын хамтын ажиллагааг дэмжих, аутсорсингийн үйлчилгээг нэвтрүүлэх нөхцөл бололцоог нэмэгдүүлэх чиглэлээр:

4.2.1.1 Аутсорсингийн үйлчилгээ үзүүлэх чиглэл, холбогдох дүрэм журмыг боловсруулах, тогтолцоог бүрдүүлэх;

4.2.1.2 Аутсорсингийн салбарын хувь хүн, албан байгууллагуудыг холбож өгөх, хоорондын харилцаа холбоог сайжруулах, хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх;

4.2.1.3 Аутсорсинг эрхлэгч байгууллагад дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах;

4.2.1.4 Аутсорсингийн зуучлах төвүүдийг байгуулах санаачлагыг дэмжих;

4.2.2 Инкубаторын болон технологийн компаниудын аутсорсинг эрхлэх үйл ажиллагаа, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх чиглэлээр:

4.2.2.1 Паркаас инкубаторын компаниудад үзүүлэх багц үйлчилгээг нэмэгдүүлэх;

4.2.2.2 Инкубаторын болон технологийн компаниудын мэргэжилтний ур чадвар, мэргэшүүлэх сургалтанд хамрагдахад туслах;

4.2.2.3 Инкубатор, технологийн компаниудын эрхлэн явуулж буй судалгаа хөгжүүлэлтийн ажлыг дэмжих, шинэ технологи бүтээхэд нь туслах;

4.2.2.4 Инкубатор, технологийн компаниудын хүний нөөцийг чадавхижуулах талаар бодлого боловсруулах;

4.2.2.5 Хөүмсөрсинг /home-sourcing/ хийх тогтолцоог бий болгох;

4.2.3 Аутсорсингийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, мэдээ мэдээллээр инкубатор, технологийн компаниудыг ханган ажиллах;

- 4.2.3.1 Аутсорсингийн үйл ажиллагаанд оролцогч талуудыг холбосон цахим орчныг бүрэлдүүлэн бий болгох;
- 4.2.3.2 Аутсорсингийн үйл ажиллагааг идэвхижүүлэх талаар сургалт, семинар зохион байгуулах, бусад идэвхижүүлэлт хийх;
- 4.2.3.3 Инкубатор, технологийн компаниудын үйл ажиллагааг тэлхэд нь туслах;

Тав. Хүрэх үр дүн, удирдлага зохион байгуулалт

- 5.1 Аутсорсингийн дэд бүтэц, тогтолцоо бүрдэхэд үндэс суурь нь болох;
- 5.2 Аутсорсингийн бодлогыг хэрэгжүүлэх талаарх төлөвлөгөө гарган мөрдөн ажиллах, холбогдох дүрэм журмыг боловсруулан байгуулах;
- 5.3 Төр, Эрдэм шинжилгээний байгууллага, аж үйлдвэрийн хамтын ажиллагаа идэвхижнэ;
- 5.4 Дотоодын аж ахуй нэгжийн үргүй зардал багасна;
- 5.5 Монгол улс дахь гадаадын валютын урсгал нэмэгдэх боломж бүрдэнэ;
- 5.6 Аутсорсинг нийлүүлэгч гадаадын орнуудтай хамтын ажиллагааг бий болгох, цаашлаад инкубатор, технологийн компаниудын гадаадын зах зээлд нэвтрэх боломж бүрдэнэ;
- 5.7 Дэлхийн тэргүүлэх аутсорсингийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудтай хамтран ажиллах боломж бүрдэнэ;
- 5.8 Бодлогын баримт бичгийг батлах болон нэмэлт өөрчлөлт оруулахдаа Мэдээллийн технологийн үндэсний паркын удирдлагын багаар хэлэлцүүлсний үндсэн дээр ерөнхий захирлын тушаалаар батлана.